

# СОЁМБО МЭДЭЭ

## ТӨРИЙН ДЭЭД ЦОЛ ХҮРТСЭН АЛБА ХААГЧ, АХМАДУУДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЛЭЭ



Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр болон сайдын зөвлөлийн гишүүд өнөөдөр Батлан хамгаалах яаманд Төрийн дээд цол хүртсэн зарим алба хаагч, ахмадад хүндэтгэл үзүүлжээ. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Чингис хааны одон хүртсэн сансрын нисгэгч, чөлөөнд байгаа хошууч генерал Ж.Гүррагчаа, Монгол Улсын ардын багш хэмээх хүндтэй цол хүртсэн ҮБХИС-ийн ахмад ажилтан, бэлтгэл хурандаа Г.Мягмаржав, шинжлэх ухааны гавьяат ажилтан цолоор шагнагдсан БХЭШХ-ийн АББХСТ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, чөлөөнд байгаа хошууч генерал О.Үржин, БИЦУГ-ын дарга, Монгол Улсын хөдөлмөрийн баатар,

дэд хурандаа Д.Жаргалсайхан, орлогч дарга, гавьяат барилгачин, хурандаа Ц.Ганхөлөг, Зэвсэгт хүчний 7781 дүгээр ангийн захирагч, гавьяат барилгачин хошууч генерал П.Доржсүрэн, ачаа тээврийн бүлгийн жолооч, гавьяат тээвэрчин, ахлах ахлагч Б.Мөнхтөр, “Алдар” спорт хорооны Биеийн тамир чийрэгжүүлэлтийн төвийн дарга, ерөнхий арга зүйч, гавьяат тамирчин, дэд хурандаа Д.Ганхуяг, Их спортын албаны Техник хэрэгслийн спортын бүлгийн туслах дасгалжуулагч, гавьяат тамирчин, дэслэгч М.Анхцэцэг, Үндэсний спортын албаны оюуны спортын бүлгийн дасгалжуулагч, дэслэгч Ө.Дүүрэнбаяр, тус хорооны ахмад ажилтан, гавьяат дасгалжуулагч,

бэлтгэл хошууч Ч.Гочоосүрэн, Цэргийн төв эмнэлгийн дарга, ерөнхий эмч, эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан, хурандаа С.Батболд, сувилагч А.Сольхүү нарт хүндэтгэл үзүүлж, баяр хүргэлээ.

Энэ үеэр Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр “Та бүхэн Батлан хамгаалах, Зэвсэгт хүчиндээ хоёргүй сэтгэлээр зүтгэж, төрөөс өгсөн үүрэг даалгаврыг маш сайн биелүүлж, улс орны боловсрол, эрүүл мэнд, спортын салбар, бүтээн байгуулалтад томоохон хийц дэвшил авчирсан гэдгийг хэлэх нь зүйтэй. Салбарынхаа нэр хүндийг өндөрт өргөсөөр ирсэн та бүхний хөдөлмөр зүтгэлийг үнэлж, төрийн дээд цол хүртээн, шагнаж урамшуулсан

явдалд Батлан хамгаалах яамны удирдлага, сайдын зөвлөлийн гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, цаашдын ажил хөдөлмөрт нь амжилт, гэр бүлд нь аз жаргал, эрүүл энхийг хүсэн ерөөе” гээд дурсамж гардуулав.

Энэ үеэр сансрын нисгэгч, чөлөөнд байгаа хошууч генерал Ж.Гүррагчаа “Өнөөдөр сайд болон сайдын зөвлөлийн гишүүд Батлан хамгаалах салбараас төрсөн хөдөлмөрийн баатар, генерал, гавьяатуудын хамтаар хүлээж авсан явдалд миний бие баяртай байна. Миний амьдрал Монголын Ардын Армитай салшгүй холбоотой. Би Зэвсэгт хүчний эгнээнд байгаагүй бол, Зэвсэгт хүчний офицер байгаагүй бол энэ баярт үйл явдлын гадна үлдэх байсан ч байж мэднэ. Амьдралдаа хийсэн чухал сонголтуудын минь нэг бол Зэвсэгт хүчин. Үүгээрээ ч бахархдаг” хэмээгээд Батлан хамгаалах яам, ЗХЖШ-ын удирдлагад ажлын амжилт хүсэв.

Мөн гавьяат багш, бэлтгэл хурандаа Г.Мягмаржав “Би 1970 оны цэрэг. Зэвсэгт хүчний 100 жилийн тэн хагаст нь алба хаасан. Бие бүрэлдэхүүнийг сургаж хүмүүжүүлэх үйлсэд хоёргүй сэтгэлээр 50 гаруй жил зүтгэсэн. Дөнгөж сая сайдын надад гардуулсан дурсамжид энэ талаар бичиж үлдээсэн нь тун сайхан санагдлаа. Өнгөрсөн хугацаанд Зэвсэгт хүчний гурван үеийг сургаж бэлтгэжээ. Сайдаасаа эхлээд бүгд л надаас номын дуу сонссон хүмүүс энд хүрэлцэн ирсэн байна. Багш хүн үргэлж шавиа харж, тэднээрээ бахархаж явдаг учиртай. Энэ чанараараа багшийн ажил их сайхан ажил. Монгол Улсын Ардын багш хэмээх хүндтэй цол хүртсэн нь шавь нарын маань ач, гавьяа” гэсэн юм.

ЦАГ АГААР	
УЛААНБААТАР	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 17	🌧️ 3
ӨМНӨД СУДАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 35	🌧️ 24
АФГАНИСТАН	
ӨДӨР	ШӨНӨ
☀️ 29	🌧️ 16

ВАЛЮТЫН ХАНШ		
ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.844.00	2.855.00
EUR 🇪🇺	3.442.00	3.484.00
CNY 🇨🇳	442.50	446.60
RUB 🇷🇺	38.90	40.60
JPY 🇯🇵	25.61	26.10
KRW 🇰🇷	2.46	2.60

### ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 8  
2021.06.18.  
/БААСАН ГАРАГ/  
**ЗУНЫ ДУНД ХӨХ МОРЬ САРЫН НЭГ ЦАГААН УЛААГЧИН ТАХИА ӨДӨР**

Үс засуулбал:  
**Нас уртасна**  
Наран ургах, шингэх:  
**04.53-20.54**  
Барилдлага:  
**Үл тохирох**  
Шүтэн барилдлага:  
**Мунхрахуй**  
Суудал:  
**Шороо**

Ардын тооллын 8 сарын 18, Суураг гараг. Билгийн тооллын 8, Бага морь одтой, улаан бич өдөр. Өдрийн наран 4 цаг 53 минутад мандан, 20 цаг 54 минутад жаргана. Тухайн өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адеуус номхруулах, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн чанд зөвлөгөөн хийх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсоод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал нас уртасна.

## 14 НЭР ТӨРЛИЙН 8400 ГАРУЙ МОД ТАРЬЖЭЭ



Орчин цагийн Зэвсэгт хүчинтэйгээ нас чацуу Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн түүхт 100 жилийн ой энэ онд тохиож байна. Тус анги нь 100 жилийнхээ ойг тохиолдуулан олон төрлийн ажил, арга хэмжээ зохион байгуулж байгаагийн дотор

“Жишиг ногоон байгууламжтай анги” төслийг хэрэгжүүлэн ангийн байрлалд мод бут тарьж зүлэгжүүлэн экологийн байгууламжтай анги болох эхлэлээ тавиад байгаа юм. Энэ бүгд нь “Жишиг цэргийн хотхон”, “Жишиг ногоон байгууламжтай анги”

төслүүдийг боловсруулан хэрэгжүүлж байгаагийн эхлэл бөгөөд тус ажлын гүйцэтгэлтэй Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай, БХЯ-ны ТЗУГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа, ЗХЖШ-ын Материал хангалтын газрын дарга, бригадын генерал М.Мөнхбаяр,

тус газрын Зэвсгийн хэлтсийн дарга, хурандаа П.Чинзориг нар танилцлаа.

Зэвсэгт хүчний 015 дугаар ангийг жишиг ногоон байгууламжтай анги болгох ажлыг 3 дугаар сард эхлүүлсэн ба одоогийн байдлаар ангийн нийт талбайн 3000 метр квадратыг зүлэгжүүлж, 3,5 га газарт нарс, гацуур, хус, монос, чацаргана, гүйлс, далан гэх мэтчилэн 14 нэр төрлийн 8400 гаруй модыг тариад байна. Нийт тарьсан модны 1000 гаруй нь шилмүүст мод аж. Мөн спорт талбай, ерөнхий цэргийн саад, 350 метр урт гүйлтийн зам, сагс, элсний волейболын талбай зэргийг шинээр тохижуулан шинэчилжээ.

Тус ангид ажиллах үеэрээ Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай “Зэвсэгт хүчний бүхий л нэгтгэл, анги ногоон орчинд үйл ажиллагаагаа явуулах нь чухал. Хот, хөдөөд хэрхэн мод зүлэг тарьж, түүнийгээр арчлан хамгаалж болдгийг Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн үлгэрлэх нь нийгэмдээ үзүүлж буй эерэг нөлөөлөл юм. Нэгтгэл, анги бүрийг ногоон болгох хүн хүчний нөөц боломж бидэнд хангалттай бий. Зөв зохион байгуулалт, зөв төлөвлөлт, сэтгэл зүтгэл байхад бүрэн хэрэгжинэ гэдэгт эргэлзэхгүй байна” гэлээ.

## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН	ЭДГЭРСЭН	НАС БАРСАН
88.516	61.725	411/11
ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ		
НИЙТ БАТЛАГДСАН	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ	ЭДГЭРСЭН
3026 (46)	367	2611

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

- Тохиолдол  
Нийт: 178,196,019
- Эдгэрсэн  
Нийт: 162,692,818
- Нас барсан  
Нийт: 3,857,846

**Хүүхдийг КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)- ААС СЭРГИЙЛБЭ!**

## АФГАНИСТАН УЛСАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН АЛБА ХААГЧДАД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад үүрэг гүйцэтгэсэн цэргийн багуудад хүндэтгэл үзүүлээ. Хүндэтгэл үзүүлэх ёслолын ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл С.Клечески болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, БХЯ, ЗХЖШ, Төрийн цэргийн командлал, төрийн цэргийн байгууллагын удирдлагууд оролцов.

Монгол Улс, НҮБ-ын хооронд 1999 онд байгуулсан цэргийн хүч нийлүүлэх тухай "Харилцан ойлголцлын санамж бичиг", УИХ-аас 2002 онд баталсан "Цэрэг, цагдаагийн алба хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон Олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" хуулийн дагуу Монгол Улсын Зэвсэгт хүчин 2003 оноос эхлэн Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад энхийг дэмжих ажиллагаанд оролцож, үүргээ амжилттай гүйцэтгэж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад

-2003-2011 онд "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд артиллерийн сургалтын хөдөлгөөнт багийн 265 офицер, ахлагч 13 ээлжээр,

-2009-2015 онд "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд мотобуудлагын ротын 1,252 алба хаагч 10 ээлжээр,

-2010-2015 оноос "Аюулгүй байдлын дэмжлэг үзүүлэх олон улсын хүчин" ажиллагаанд нисдэг тэрэгний засвар үйлчилгээний сургалтын бүлгийн 54 цэргийн алба хаагч 9 ээлжээр, хамгаалалтын салааны 439 алба хаагч 8 ээлжээр,

-2015 оноос "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд 1,356 алба хаагч 12 ээлжээр тус тус үүрэг гүйцэтгэсэн юм.

Ийнхүү Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад АНУ-тай хамтарсан энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс давхардсан тоогоор 3,300 орчим цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж, сүүлийн ээлжийн бие бүрэлдэхүүн 2021 оны 6 дугаар сарын 4-ний өдөр эх орондоо ирээд байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч Х.Баттулга энэ үеэр хэлсэн үгэндээ "Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдсан цэргийн ажиллагаануудад АНУ-тай

хамтран үүрэг гүйцэтгэсэн цэргийн багуудад хүндэтгэл үзүүлэх ёслолд хүрэлцэн ирсэн Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлж.

2019 оноос өнөөг хүртэлх 30 жилийн хугацаанд Монгол, АНУ хоёр улсын батлан хамгаалах салбар дахь харилцаа, хамтын ажиллагаа нь Монгол Улсын батлан хамгаалах салбарын шинэчлэлд дэмжлэг үзүүлэх, Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхыг бэхжүүлэх, харилцан туршлага солилцох, хамтран үүрэг гүйцэтгэх, бүс нутгийн тогтвортой байдлын талаар харилцан санал солилцох зэрэг чиглэлээр эрчимтэй хөгжиж ирсэн.

Хоёр улсын Зэвсэгт хүчний хамтын ажиллагаа нь талуудын нийтлэг эрх ашиг болох ардчилал, эрх чөлөө, хүний эрхийг дэлхий дахинд хамгаалах, хоёр орны ард түмний найрсаг харилцааг гүнзгийрүүлэх, бүс нутагт болон дэлхий дахинд цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалахад чухал үүрэг гүйцэтгэсэн ирсэн билээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллагатай 1999 онд цэргийн хүч нийлүүлэх тухай "Харилцан ойлголцлын санамж бичиг"-ийг байгуулж, 2002 онд УИХ-аас "Цэрэг, цагдаагийн алба хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон Олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай" хуулийг баталснаар Монгол Улс энхийг дэмжих ажиллагаанд Зэвсэгт хүчнээ оролцуулах эрх зүйн үндэс бүрдэж, тухайн жилдээ манай цэргийн албан хаагчид анхлан НҮБ-ын цэргийн ажиллагчаар үүрэг гүйцэтгэж эхэлсэн түүхтэй.

Харин 2003-2008 оноос цэргийн багийн бүрэлдэхүүнээр "Иракийн эрх чөлөө" дайны дараах сэргээн босголт, олон улсын хүмүүнлэгийн ажиллагаанд оролцох болсон. Аль Хилла хот дахь "Чарли" болон "Эко" цэргийн баазын аюулгүй байдлыг хангах үүргийг монгол цэргүүд нэр төртэйгөөр гүйцэтгэсэн байдаг. Монголын Зэвсэгт хүчний 10 ээлжийн цэргийн баг, нийт 1,195 цэргийн алба хаагч үүрэг гүйцэтгэж, мэргэжлийн ур чадвар, тэсвэр хатуулжлыг нотлон харуулсан билээ. Нэгэн тод жишээ нь, 2004 оны 2 дугаар сарын 18-ны өдөр 750 килограмм тэсрэх бодис бүхий амиа золиослогчийн халдлагыг таслан зогсоосон ахлагч Г.Азаяа, Ш.Самбуу-Эндон нарын гавьяа юм. Тэд 2000 гаруй цэргийн алба хаагч байрлаж байсан баазыг үхлийн аюулаас аварсан юм. Монгол дайчдын эр зоригийг үнэлж Польш Улс "Мөнгөн загалмай" одонгоор шагнаж байв.

2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлагад өртсөний

дараа Америкийн Нэгдсэн Улс тэргүүтэй Эвслийн цэргийн хүчин Афганистан дахь Талибаны засаг захиргаа, "Аль Кайда" зэрэг олон улсын террорист бүлгийн үйл ажиллагааг таслан зогсоох ажиллагааг эхлүүлсэн. Монгол Улс Эвслийн цэргийн "Тогтвортой эрх чөлөө", НАТО-ийн цэргийн "Аюулгүй байдлыг дэмжих олон улсын хүчин", "Шийдвэртэй дэмжлэг" гэсэн гурван ажиллагаанд цэргийн багуудаа илгээсэн.

Афганистанд үүрэг гүйцэтгэсэн анхны баг нь артиллерийн сургалтын хөдөлгөөнт баг байв. Түүнээс хойш 2003-2011 онд 13 ээлж, 2010 оны 10 дугаар сараас нисдэг тэрэгний засвар үйлчилгээний сургалтын 9 ээлжийн бие бүрэлдэхүүн Афганистанд үүрэг гүйцэтгэжээ.

2009 оны 9 дүгээр сараас "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд мотобуудлагын ротыг илгээж, нийт 10 ээлжийн цэргийн баг үүрэг гүйцэтгэсэн бол хамгаалалтын салаа нь 8 ээлжээр Кабул хотын олон улсын хүчний нисэх буудлын аюулгүй байдлыг хангах, хариуцлагын бүсэд эргүүл хийх, хайгуулын ажиллагаа явуулах зэрэг үндсэн үүргүүдийг гүйцэтгэжээ.

2015 оны 1 дүгээр сарын 1-нээс "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд Монголын Зэвсэгт хүчнээс 12 ээлжийн цэргийн баг үүрэг гүйцэтгэсэн байна.

Афганистан Улсад Монголын Зэвсэгт хүчний цэргийн багууд үүрэг гүйцэтгэснээр бид даян дэлхийн энх амгалангийн үйл хэрэгт өөрийн хувь нэмрийг оруулсны зэрэгцээ эртний дайчин түүх, уламжлалтай Монгол цэргийн нэр хүндийг ахин таниулж, мэргэжлийн ур чадвар, сахилга бат, зохион байгуулалтаараа бусад улсын төр, засгийн удирдлага, цэргийн мэргэжилтнүүд, цэргийн алба хаагчдад зүй ёсоор хүлээн зөвшөөрөгдөж, байнгын үлгэр дуурайл болсоор ирснийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн хувьд онцлон тэмдэглэж байна. Та бүхнээр Монголын ард түмэн бахархаж, омогшиж байгаа. Өвөг дээдсийн дайчин нэр төрийг хамгаалж, өндөрт өргөж ирсэнд Та бүгдэд ард түмнийхээ нэрийн өмнөөс талархал илэрхийлье. Монгол цэрэг -Дэлхийн цэрэг, Монгол цэрэг-Чингисийн цэргүүд билээ.

Мөнх тэнгэрийн хүчин дор Монгол цэргийн жавхаа, хийморь ашид мандан бадрах болтугай! гэлээ.

Мөн үеэр ЗХЖШ-ын дарга, дэслэгч генерал Д.Ганзориг, АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Майкл С.Клечески нар үг хэлж, алба хаагчдад амжилт хүссэн юм.

## ЦАХИМ СУРГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



УИХ-аас удирдлага нь томилогддог байгууллага, яам, агентлаг, аймаг, нийслэл, дүүрэг, сумдын ЗДТГ-ын дарга, ИТХ-ын нарийн бичгийн дарга, Нийслэлийн Засаг даргын харьяа агентлагуудын захиргааны нэгжийн дарга, хүний нөөцийн асуудал, хариуцсан ажилтан, архив, бичиг хэргийн ажилтнуудыг хамруулсан "Төрийн албаны

тухай хууль болон архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт арга зүйн цахим сургалт өнөөдөр эхэллээ.

Төрийн албаны тухай хууль болон архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандартын талаарх мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхэд энэхүү сургалтын зорилго чиглэгдэж байгааг Төрийн

албаны зөвлөлийн гишүүн Д.Зүмбэрэлхам сургалтын эхэнд онцлов.

Тус сургалтаар "Сургалт судалгаа, мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа", "Хүний нөөцийн удирдлага, аудитын үйл ажиллагаа", "Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомж, стандарт" зэрэг сэдвийг хөндөж, хэлэлцүүлж өрнүүлэх юм.

### ХИЛИЙН ЧАНАДААС

## "ЮНИТИ" СЕКТОРЫН КОМАНДЛАГЧ "АРВАЙ", "ДЕЛЬТА" БААЗЫН ҮЙЛ АЖИЛЛАГААТАЙ ТАНИЛЦАВ



БНӨСУ-д явагдаж байгаа НҮБ-ын мандаттай UNMISS энхийг дэмжих ажиллагаанд "Юнити" секторын Париаг, Жам жанг сууринд Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн цэргийн багийн командлагчид танилцав.

Мөн айлчлалын бүрэлдэхүүн Жам Жанг сууринд үйл ажиллагаа явуулдаг НҮБ-ын болон олон улсын хүмүүнлэгийн байгууллагын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж цаг үеийн асуудлаар санал солилцож, үүсээд буй нөхцөл байдалд цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцав. Энэхүү уулзалтын үеэр олон улсын хүмүүнлэгийн байгууллагын удирдлагууд Жам жанг сууринд цагийн байдал тогтворгүй, халдлага дайралт, гэмт хэргийн гаралт тасрахгүй байгааг мэдээлээд 2021 оны 4 дүгээр сарын 27-нд бидний үйл ажиллагаа явуулдаг бааз руу орон нутгийн иргэд гэнэтийн халдлага үйлдэх үед богино хугацаанд цагийн байдлыг

үүрэг гүйцэтгэлт, эргүүл цуваа, харуул хамгаалалт, хариуцлагын бүс дэх цагийн байдал, "Ковид-19" цар тахлаас урьдчилан сэргийлэх хүрээнд авч хэрэгжүүлж буй ажил, арга хэмжээг танилцуулан, холбогдох үүрэг даалгавар авлаа.

Мөн айлчлалын бүрэлдэхүүн Жам Жанг сууринд цагийн байдал тогтворгүй, халдлага дайралт, гэмт хэргийн гаралт тасрахгүй байгааг мэдээлээд 2021 оны 4 дүгээр сарын 27-нд бидний үйл ажиллагаа явуулдаг бааз руу орон нутгийн иргэд гэнэтийн халдлага үйлдэх үед богино хугацаанд цагийн байдлыг

намжаахад мэргэжлийн ур чадвар гарган, ажилчдын аюулгүй байдлыг хангасанд Монголын батальоны бие бүрэлдэхүүнд хандан гүн талархаж байгаагаа илэрхийллээ.

Үүний хариуд "Юнити" секторын командлагч, бригадын генерал ДМ Шамим Камал цаашид үүсэж болзошгүй гэнэтийн халдлага, дайралтын үед та бүхний аюулгүй байдлыг хангахад Жам Жанг сууринд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын батальоны цэргийн алба хаагчид чухал үүрэгтэй. Болж өнгөрсөн цагийн байдалд түргэн хугацаанд шаардлагатай арга хэмжээ авч ажилласан нь НҮБ-ын энхийг сахиулагчдын нэр хүндийг өндөрт өргөсөн явдал байлаа.

Цаашид тус суурины аюулгүй байдалтай холбоотой асуудлыг цаг алдалгүй Монголын батальоны цэргийн алба хаагчдад мэдэгдэж байхыг хүслээ.

Ахлах дэслэгч Г.Цэрэннадмид